

Эрүүл мэндийн салбарын "2025-2028 онд хэрэгжүүлэх Стратеги төлөвлөгөө"-нд өгөх санал

Байгууллагын нэр: Нийслэлийн Өргөө амаржих газар

2025.04.30

№	Санал өгөх чиглэлүүд	Санал
1.	Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	➤ Эрүүл мэндийн салбарт ашиглаж буй программуудыг тавигдах шаардлагатай болгож, хяналт үнэлгээг тогтмол явуулдаг байх. Үйлчлүүлэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, мэдээлэл алдагдсан ажилтан албан хаагчийг мэддэг байх гэх мэт хөгжүүлэлт хийсэн байх. /ашиглаж туршиж үзсэн судалгаа, үр дүнтэй байх/ ➤ Эрүүл мэндийн салбарт ашиглаж буй Карте, Ehealth программын хоорондын уялдаа холбоог сайжруулах, мэдээлэл солилцох их өгөгдлийн санг бүрдүүлэх, нээлттэй болгох ➤ Эмнэл зүйн цахим программын хөгжүүлэлтийг сайжруулж, эмнэлгүүд мэдээлэлээ солилцох боломжийг хангах ➤ Жирэмснээс сэргийлэх эм хэрэгслийн цахим программыг боловсронгуй болгох, ХУР системээс эмэгтэйн үндсэн мэдээлэл татдаг болгох
2.	Хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхыг сайжруулах /гадаад, дотоотын сургалтад хамруулах, төгсөлтийн дараах сургалтын чиглэлээр/	➤ Сувилагч, бусад мэргэжилтний чадавхийг нэмэгдүүлэх олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх зорилгоор гадаадын сургалтад жилд 1 удаа хамруулах ➤ Төгсөлтийн дараах сургалтын чиглэлээр Нийслэлийн Өргөө амаржих газрын сургалтын явуулах төрлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх /Нярайн перинаталь судлал, нярайн сувилахуй чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн сургалтын эрх шинээр авах санал өгсөн/ ➤ Төгсөлтийн дараах сургалтын чиглэл нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Эмнэлзүйн сургагч багшийн тоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх /Сувилагч-5, нярайн эмч-2-г ТОТ сургалтад хамруулах/ ➤ Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтыг тус амаржих газар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

	Нийгмийн баталгааг хангах, сайжруулах	➤ Эрүүл мэндийн салбарын нийт ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр нэгдсэн судалгаа явуулж, үр дүнг үнэлэн сайжруулах ажлуудыг зохион байгуулах. -Мэргэшлээс шалтгаалах өвчний оношилгоо, эмчилгээнд чиглэсэн үйл ажиллагаанууд -Орон сууц, гэр, хашаа байшингийн судалгаа явуулж, нийгмийн баталгааг сайжруулах ажлуудыг зохион байгуулах /ипотект хамруулах, нээлттэй ил тод, эрх тэгш хамрагдах байдалд анхаарах/ -Эрүүл мэндийн салбарын ажилтнуудаас зорилтот бүлэгт чиглэсэн ажлууд хийх /өрх толгойлсон эмэгтэйд чиглэсэн, тэтгэвэрт гарсан ажилтан албан хаагчдад, сувилагч бусад мэргэжилтэнд чиглэсэн гэх мэт/ ➤ Сувилагч, бусад мэргэжилтний мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх бодитой арга хэмжээ авах. /үнэгүй сургахаас илүүтэйгээр тухайн сонгосон мэргэжлийн ажлын байран дахь үнэлэмж, ачааллыг багасгах тал дээр анхаарах/
4.	Эрүүл мэндийн байгууллагын чанар, аюулгүй байдал, магадлан итгэмжлэл	➤ Тухайн жилд тухайн байгууллагад хяналт-үнэлгээ, шалгалтын бүх байгууллагаас ирсэн шалгалтад орсон тохиолдолд тайланг харгалзан үзэж магадлан итгэмжлэлийг сунгадаг байх. ➤ Магадлан итгэмжлэлийн үйл явцыг зохицуулсан хууль, дүрэм, стандартуудыг шинэчлэх, сайжруулах, шалгуур үзүүлэлтийн давхардлыг арилгах ➤ Шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний нөхцөл байдалд нийцүүлэн боловсронгуй болгох ➤ Эмнэлгийн удирдлага, ажилтнуудыг чанарын удирдлагын чиглэлээр тогтмол сургах ➤ Чанарын мэдээллийг удирдах нэгдсэн цахим платформ систем нэвтрүүлэх ➤ Дата шинжилгээнд суурилсан шийдвэр гаргах соёлыг төлөвшүүлэх ➤ Магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагааг цахимаар хянах, ил тод болгох ➤ JCI олон улсын стандартад нийцсэн хөтөлбөр хэрэгжүүлэх

5.	Гадаад эмчилгээнд хамруулах	➤ Өндөр настны тэтгэвэрт гарсан эрүүл мэндийн салбарын хүндэт ажилтанг гадаад улсад 1 удаа оношилгоо, эмчилгээнд хамруулдаг байх. ➤ Гадаад эмчилгээг зохицуулах үйл ажиллагааг нээлттэй ил тод байлгах, мэдээллэх ➤ Иргэдийг тэгш эрхтэйгээр гадаад улсын эмчилгээнд хамруулах ➤ МУ-д эмчлэгддэггүй өвчлөлийн жагсаалтаас гадна эрхтэн шилжүүлэн суулгах шаардлагатай ч донор байхгүй улмаас хүлээлгэнд байгаа иргэдийг гадаад улсад эмчлүүлэх боломжоор хангаж дэмжлэг үзүүлэх
6.	Үзүүлж буй тусламж үйлчилгээнд тулгарч буй саад бэрхшээл /бусад санал/	➤ Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалыг бий болгох ➤ Өндөр эрсдэлтэй тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамгаалах хууль эрх зүйн орчинг бий болгох /хууль эрх зүйн орчин байхгүйгээс айдастай мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл их тулгардаг/ ➤ ЭМД-ийн тусламж үйлчилгээний өртгийн жинг нэмэгдүүлэх. ➤ КРІ үнэлгээгээр цалин хөлсийг бодож олгохыг хууль тогтоомжид тусгах санал гаргах, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх ➤ ЭМД-ын тогтоол 2025 оны 03-р сард шинэчлэн батлагдсан боловч Карте программд тухайн тогтоолд орсон шинэчлэлүүд хийгдэж дуусаагүй байна. Тус программд хийгдэх шаардлагатай шинэчлэлүүд, ачаалал ихтэй үед гацалт үүсч, тусламж үйлчилгээнд хүлээгдэл үүсч иргэдэд хохирол мөн ЭМД-ын санхүүжилт орж ирэхгүй гэх мэт санхүү болон бучад асуудал удаа дараа үүсч байгаа тухай санал хүсэлтийг Карте программыг хөгжүүлэгч Axis компанид хүргүүлсэн боловч одоо болтол бодитой арга хэмжээ аваагүй болно.

Саналыг нэгтгэсэн:



Б.Оюунсайхан /СЭШХАА-ны дарга/